



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 01 сарын 03 өдөр

Дугаар 01

Номгон

“Амар тайван амьдрал” аймгийн
дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.9 дэх хэсэгт заасныг үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Амар тайван амьдрал” аймгийн дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тухайн жилийн төсөвт тусгаж байхыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д үүрэг болгосугай.
3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, мөрдүүлэх, хэрэгжүүлэх ажлыг эрчимтэй зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс /Д.Уранчимэг/, Цагдаагийн газар /Б.Оюутболд/, Онцгой байдлын газар /Т.Мөнхбаатар/, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /Н.Мэндбаяр/, Байгаль орчин, аялал жуулчлалын газар /Б.Бат-Өлзий/ нарт тус тус даалгасугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.



0117263

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 01 дүгээр сарын
03-ны өдрийн 01 дүгээр тогтоолын хавсралт



**“АМАР ТАЙВАН АМЬДРАЛ”
АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР**

Нэг. Иргэдийн амар тайван амьдралын өнөөгийн байдал

Баянхонгор аймаг нь 2016 оны жилийн эцсийн байдлаар 20 сумтай, 104 багтай 85331 хүн амтай, үүнээс 0-17 наасны 30597 хүүхэд /35.8%, 18-35 наасны залуучууд 22988 /26.9%, өндөр настан 5.4% /4608/, эмэгтэйчүүд 50.6% /43177/ хувийг тус тус эзэлдэг.

Аймгийн хэмжээнд 25423 өрхтэй тэдний 34.5 % аймгийн төвд, 12.4 % сумын төвд, 51.6% хөдөөд, 1.5 хувь нь тосгонд байна.

Эдгээр иргэдээс аймгийн Цагдаагийн газарт 143, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газарт 15, Онцгой байдлын газарт 149, Байгаль орчин, аялал жуулчлалын газарт 45 албан хаагч ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд сүүлийн 3 жилд /2014 онд 430, 2015 онд 360, 2016 онд 356/ нийт 1146 гэмт хэрэг бүртгэгдсэний 342 буюу 33.6 хувийг нь өмчийн хулгайн гэмт хэрэг, 80 буюу 7.8 хувийг нь малын хулгайн гэмт хэрэг, 86 буюу 8.4 хувийг нь хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, 93 буюу 9.1 хувийг нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг, 341 буюу 33.5 хувийг нь согтуугаар үйлдсэн гэмт хэрэг, 179 буюу 17.6 хувийг нь гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг эзэлж байна.


Гэмт хэргийн улмаас 1019 хүн хохирч, 1.541.6 сая төгрөгийн эдийн засгийн хохирол учирсан байна.

Тус аймгийн хувьд гэмт хэргийн илрүүлэлт жил бүр өссөн үзүүлэлттэй байна. Тухайлбал: 2014-2016 онд 67.7-74.4 хувьтай байгаа нь улсын дундаж үзүүлэлтээс дээгүүр байна.

Аймгийн хэмжээнд 0-17 наасны 35.9% /30621/ хүүхдээс 6-17 наасны хүүхэд 53.7% /16443/ хагас өнчин 5.01% /1535/ хүүхэд, бүтэн өнчин 0.36% /111/ хүүхэд байна.

Хөдөлмөр эрхэлдэг хүүхэд 2015-2016 онд 0.12% /814-813/ хүчирхийлэлд өртсөн хүүхэд 2015-2016 онд 10.5%-ийн /38-34/, сургууль завсардсан хүүхэд 2016 онд 0.9% -иар /76-69/ буурсан байна.

Насанд хүрээгүй хүн оролцсон гэмт хэрэг 2016 онд 21 бүртгэгдэж өмнөх оноос 36.3 хувиар буурсан бол 2017 оны эхний 2 сарын байдлаар 13 бүртгэгдсэн нь энэ төрлийн гэмт хэрэг өсөх хандлагатай байна.



Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой зөрчил 2015 онд 26, 2016 онд 41 буртгэгдэж 15 нэгжээр, 57.7 хувиар өссөн байна.

2015 онд 105, 2016 онд 59 гэр бүл гэрлэлтээ цуцлуулсан бөгөөд тэднийг насны байдлаар авч үзвэл 35 доош насны залуучууд байна.

Аймгийн хэмжээнд объектын түймэр ихэвчлэн гардаг ба энэ нь ард иргэдийн санамсар болгоомжгүй байдлаас мөн эзэн шалтгаан нь тогтоогдоогүй гал түймрийн хэрэг зөрчил гарч байна. 2014 онд 38 удаа гал түймэр гарч 96.6 сая төгрөгийн хохирол, 2015 онд 28 удаагийн гал түймэр гарч 73.5 сая төгрөгийн хохирол, 2016 онд 32 удаа гал түймэр гарч 116 сая төгрөгийн хохирол учирч нийт 98 удаагийн объектын түймэр гарч 286.1 сая төгрөгийн хохирол учирсан ба 6 хүн амь насаа алдаж 4 хүн түлэгдэж гэмтсэн.

Ой хээрийн түймэр 4 удаа гарч байгаль экологид 3,5 сая төгрөгийн хохирол учирсан. Зарим гал түймрийн эзэн шалтгааныг тогтоож чадахгүй байна.

Гал түймрийн аюулаас төр, аж ахуй нэгж, ард иргэдийн 3,8 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг авран хамгаалсан.

Дээрх хугацаанд гамшиг, ослын дуудлагыг төрлөөр нь авч үзвэл: Усны осол 10 удаа гарч 4 хүн амь насаа алдсан. Уул, уурхайн осол 3 удаа гарч 5 хүн амь насаа алдсан. Хүн малын гоц халдварт боом өвчин 3 удаа гарсан, Галзуу өвчин 9 удаа гарсан.

Тус аймаг нь 6-8 баллын хүчтэй газар хөдлөлтийн бүсэд оршдог ба жилд 3,5-5,2 баллын хүчтэй газар хөдлөлт дунджаар 3-5 удаагийн тохиолдол болдог. Одон орон гео физикийн судалгааны төвөөс мэдээлж байгаагаар зөвхөн газар хөдлөлтийн багажид мэдрэгдэм чичирхийлэлт эрс нэмэгдсэн гэсэн мэдээллийг өгч байна.

Аймгийн хэмжээнд 2017 онд 13 сумын нутаг дэвсгэрт 500597.37 га талбай буюу ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 50 аж ахуй нэгжийн тусгай зөвшөөрөл, 15 сумын нутаг дэвсгэрийг хамарсан 486532.26 га талбай буюу 74 аж ахуй нэгжийн 99 хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсон байна.

Байгаль орчин, аялал жуучлалын газрын харьяа байгаль, хамгаалагч болон сумдад ажиллаж буй БОХУБ нар нь 931 удаагийн хяналт шалгалтаар 337 зөрчил илрүүлж, 176 зөрчилд 12411800 төгрөгийн торгуулийн арга хэмжээг авсан байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас жил бүр Баянхонгор аймгийн төвийн 5 цэгээс /Мазаалай парк, Динозавр парк, 1 дүгээр баг 18 дугаар байр, Дэлгэрэх зах, Есөн эрдэнэ зах/ хөрсний дээж авч нян судлалын үзүүлэлтээр шинжилгээнд хамруулахад нянгийн бохирдол зөвшөөрөгдөх хэмжээнээс 5-20 дахин их, зарим цэгт гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян илэрсэн байна

Хоёр. Хөтөлбөр боловсруулах шаардлага

Монгол Улсын иргэн бүр эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах, төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг

зөрчихөөс урьдчилан сэргийлэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг төр иргэнийхээ өмнө хариуцдаг.

Аймгийн гэмт хэргийн шинж байдлаас харахад хулгайн гэмт хэрэг өндөр байгаа нь иргэдийн амьжиригааг дэмжих, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэдийн оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлэх, шаардлагатай байна.

Гэмт хэргийн илрүүлэлт улсын дунджаас дээгүүр байгаа нь тухайн асуудал хариуцсан төрийн байгууллагын ажил хангалттай сайн ажиллаж байгаа ч олон нийтийн оролцоо хангалтгүй байна.

Гэмт хэрэг, зөрчлийг шуурхай таслан зогсоох нь иргэдийн аюулгүй байдлыг хангахаас гадна иргэдийг гэмт хэрэгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, иргэдийн амар тайван аюулгүй байдлыг бүрдүүлэхэд иргэн, аж ахуй нэгж байгууллага, хууль хяналтын байгууллагуудын хамтын ажиллагаа чухал байна.

Хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ажилд эцэг эхийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх, хүүхдэд бага наснаас нь эхлэн зан төлөвшил, хүмүүжлийн арга хэмжээ байнгын авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Ерөнхий боловсролын ахлах ангийн 750 гаруй сурагчдаас хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд хэний оролцоо чухал вэ? гэсэн асуулга авахад Эцэг эхийн хараа хяналт сул байгаагаас хүүхэд гэмт хэрэгт холбогдох, хүчирхийлэлд өртөж байна хэмээн 413 сурагч буюу 73.4 хувь, насанд хүрээгүй хүний хүмүүжилд ямар хүчин зүйл илүү нөлөөлдөг вэ? гэсэн асуултад 233 буюу 31.1 хувь нь гэр бүлийн орчин нөлөөлнө гэж тус тус хариулсан байна.

Үүнээс харахад хүүхэд гэмт хэрэгт холбогдох, гэмт хэргийн золиос болж байгаа нь эцэг эхийн хараа хяналт, анхаарал халамж сул, хүүхдийн хүмүүжил, зан төлөвшилд гэр бүлийн орчин ихээхэн нөлөө үзүүлж байгааг харуулж байна.

Ерөнхий боловсролын сургуульд байх үеэс нь эхлэн гэр бүлийн үнэ цэнэ, үр хүүхдийн нандин холбоог сайтар ойлгуулан таниулах хэрэгцээ шаардлага ихээр гарч ирж байна.

Мөн залуу гэр бүлд чиглэсэн тодорхой бодлого боловсруулах шаардлагатай нь харагдаж байна.

Монгол Улсын иргэн байгаль орчноо хамгаалах журамт үүргийг Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулж өгсөн байdag.

Байгаль цаг агаарын болоод хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Гамшигийн эрсдэл эмзэг байдлыг бууруулахад иргэд олон нийтийн оролцоог идэвхжүүлэх, иргэдийн анхаарал болгоомжийг дээшлүүлэх, эх орон, төрөлх нутгаа

хамгаалах сэтгэлгээг багаас нь төлөвшүүлэх, гал түймрийн аюул осол болон үер усны аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэд, аж ахуй нэгж, байгууллага, албан тушаалтнуудыг соён гэгээрүүлэх чиглэлээр тодорхой төрлийн ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэх ёстой.

Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль, орчны тэнцэлтэй уялдуулах, өнөө болон хойч ирээдүйн үеийнхний эрх, ашиг сонирхлын үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, жам ёсны боломжтойг нь нөхөн сэргээхтэй холбогдож төр иргэн, аж ахуй нэг байгууллагын уялдаа холбоог сайжруулах шаардлагатай байна.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 150 дугаар хэсэг болон аймгийн нийгэм, эдийн засгийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 136 дугаар хэсэгт “Амар тайван амьдрал” хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэхээр тусгагдсан нь хөтөлбөр боловсруулах хэрэгцээ шаардлага болсон.

Архидан согтуурах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гаралтыг бууруулах, гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих тэдэнд соён гэгээрүүлэх төрөл бурийн арга хэмжээ, нөлөөллийн ажлыг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлэх, гал түймэр, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх, байгаль орчны бохирдол, хог хаягдлыг багасгах ажилд иргэн, аж ахуй нэгж байгууллагын уялдаа холбоог сайжруулах олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Амар тайван амьдрал” хөтөлбөрийг боловсруулав.

Гурав. Хөтөлбөрийн зорилго, баримтлах зарчим, хугацаа

3.1 Хөтөлбөрийн зорилго

3.1.1 Аймгийн хэмжээнд архидан согтуурах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийг дэмжих, гал түймэр, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх, байгаль орчны бохирдол, хог хаягдлыг багасгах түүнд хяналт тавих үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, нийт иргэдэд соён гэгээрүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх, хүн амын эрүүл мэнд, аж амьдрал, нийгэмд учрах сөрөг үр дагаврыг багасгахад олон нийтийн оролцоог дэмжин иргэдийн амар тайван аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

3.2. Хөтөлбөр хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

Хөтөлбөрийг дор дурдсан үндсэн зарчимд тулгуурлан хэрэгжүүлнэ.

3.2.1. Орон нутгийн онцлог хэрэгцээ шаардлагад нийцсэн хөгжлийн болон салбарын урт хугацааны бодлогыг дэмжих, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичигтэй уялдуулсан байх;

3.2.2. Архидан согтуурах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих арга хэмжээг иргэд, гэр бүл, төрөл садан, хамт олон, төрийн болон төрийн бус

байгууллага, аж ахуйн нэгжийн нэгдмэл хамтын үйл ажиллагаанд тулгуурлан зохион байгуулна;

3.2.3.Гэр бүлийн хүчирхийлэл, гэр бүл цуцалтын шалтгаан, түүнд нөлөөлөх хүчин зүйл, гэр бүлийн харилцаанд үүсэх сөрөг үр дагаврын талаарх бодитой судалгааг гаргах;

3.2.4.Хүүхэд, өсвөр үеийнхэнд Монгол ёс зан заншил, өв соёл, бахархал зөв хүмүүжил олгох үзлийг залуу гэр бүлд төлөвшүүлж, үлгэр дуурайллыг дээшлүүлэх;

3.2.5.Гэмт хэрэг, гал түймэр, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр аж ахуй нэгж байгууллага, төрийн бус байгууллагын санал, санаачлагыг дэмжих;

3.3 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

3.3.1.“Амар тайван амьдрал” аймгийн дэд хөтөлбөрийг 2017-2020 онуудад хэрэгжүүлнэ.

Дөрөв. Хөтөлбөрийн зорилт, үр дүн, үйл ажиллагаа

Зорилт 1. Гэмт хэрэг, зөрчлийг бууруулах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг эрчимжүүлэн, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, Олон нийт-Цагдаагийн хамтын ажиллагааг өргөжүүлж, архидан согтуурах явдлыг тодорхой хувиар бууруулах;

Үр дүн 1.1 Гэмт хэргийн илрүүлэлт 15 хувиар өсч, Баянхонгор аймгийн иргэдийн “Амар тайван амьдрах” орчин бүрдэж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд ахиц гарч, Олон нийт-Цагдаагийн хамтын ажиллагаа сайжирсан байна.

Зорилт 1-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

1.1.Сүүлийн 3 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн судалгаанд үндэслэн аймгийн ГХУСАЗЗөвлөл, сумдын ГХУСАЗСЗ-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр аймгийн хэмжээнд “Амар тайван амьдрал” болзолт уралдааныг зохион байгуулж, дүгнэх;

1.2.Хуулийн болон хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд “Нээлттэй өдөрлөг” арга хэмжээг сум бүрт зохион байгуулж, иргэд олон нийтийг идэвхтэй хамруулах;

1.3.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, сайжруулах зорилгоор Баянхонгор сумын гэр хорооллын гудамж, орон сууц бүрийг камержуулах, гэрэлтүүлэг хийх;

1.4.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх, иргэдэд хууль эрх зүйг сурталчлах чиглэлээр бэлтгэсэн гарын авлага, тараах материалыг олшуулан тараах үргийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудыг сайн дурын үндсэн дээр татан оролцуулах;

1.5.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангуулан ажиллаж байгаа албан хаагчдын автомашин, техник хэрэгсэл, тусгай хэрэгслүүдийг үе шаттайгаар нэмэгдүүлэх;

1.6.Архи, тамхигүй орчныг бүрдүүлсэн байгууллага, хамт олныг шалгаруулан урамшуулах, тэдний туршлагыг нийтэд сурталчлах;

1.7.Архидан согтуурахтай тэмцэх ажлын хүрээнд согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудад тогтмол хяналт шалгалтыг явуулах, архины тусгай зөвшөөрлийг цөөрүүлж, зөрчил гаргасан иргэн, аж ахуй нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг дахин олгохгүй байх талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

1.8. Сургууль бүрт “Өсвөрийн цагдаа” бүлгийг ажиллуулж, хүүхдийн эсрэг гэмт хэрэг болон хүүхэд оролцсон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээ зохион байгуулж, энэ талаар багийн хэсгийн төлөөлөгч, цагдаа нарыг чиглүүлэгч багшаар бэлтгэн чадавхжуулах;

Зорилт 2 Мал хулгайллах болон орон байрны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн хэмжээнд тодорхой ажлуудыг зохион байгуулж, “Хөршийн холбоо”, “Малчдын бүлгэм”-ийн үйл ажиллагааг идэвхжүүлж, иргэдэд чиглэсэн сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулж, хяналт шалгалтыг эрчимжүүлэх;

Үр дүн 2.1. Мал хулгайллах, орон байрны хулгайн гэмт хэргийн гаралт 30 хувиар буурч, иргэдийн амар тайван амьдрах орчин бүрдсэн байна.

Зорилт 2-ын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

2.1.Аймгийн хэмжээнд ажиллаж байгаа “Малчдын бүлгэм”-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр тодорхой ажлуудыг зохион байгуулж, тэдний үйл ажиллагааг дэмжин тусалж, олон нийтэд сурталчилах;

2.2.Мал хулгайллах гэмт хэрэг ихээр үйлдэгддэг сумдын судалгааг гаргаж, холбогдох хуулийн байгууллагуудтай хамтарсан хяналт шалгалтыг явуулж, иргэдэд анхааруулга, сээрэмжлүүлэг өгөх зорилгоор улирал бүр сургалт, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулах;


2.3.Гэмт хэрэг ихээр үйлдэгдэж байгаа багуудад агаарын нисдэг явуулын камер ажиллуулж, орон байрны хулгайг түргэн шуурхай илрүүлэх нөхцөл бололцоог ханган ажиллах;

2.4.Гэр, орон сууцаа хулгайчаас хамгаалахын тулд гудамж, байр, орцоороо хамтран гэрээт эргүүл, жижүүр ажиллуулж байгаа оршин суугчдын санаачлагыг дэмжиж ажиллах;

2.5.Орон байрны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Цагдаагийн байгууллага санаачлан багийн Засаг дарга, оршин суугч, иргэдийн дэмжлэг хамтын ажиллагааны хүрээнд “Аюулгүй гудамж” төсөл хэрэгжүүлэх;

2.6.Мал хулгайллах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн төвд мал амьдаар нь худалдан авах болон мал нядалгааны цэгийг бий болгох;

2.7.Мал хулгайллах гэмт хэрэгтэй тэмцэхэд голлох үүрэг бүхий малчдын бүлгийн үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор малчдын бүлгийн гишүүд ахлагч нарт урамшуулал олгох, уралдаан зарлах асуудлыг шийдвэрлэх;



2.8. Аймгийн хэмжээнд мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх дэд хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх;

Зорилт 3 Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн болон насанд хүрээгүй хүүхдийн үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох төрийн байгууллагуудтай хамтарсан сургалт, соён гэгээрүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх;

Үр дүн 3.1. Төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирч, гэмт хэрэг жил бүр 5 хувиар буурсан байна.

Зорилт 3-ын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, ойлголт, мэдлэг, хандлага, ухамсыг дээшлүүлэх, энэ талаарх хууль тогтоомжийг сурталчлах асуудлаар олон нийтэд зориулсан зөвлөмж, гарын авлага бэлтгэн олон нийтэд хүргэх, ухуулга, сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хэрэгжүүлэх;

3.2. Гэр бүлийн хүчирхийллийн чиглэлээр олон нийтэд зориулсан албан бус сургалт, сурталчилгааны ажлыг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах;

3.3. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч болон хохирогчийн талаарх мэдээллийн санг бүрдүүлэх, статистик мэдээллийг боловсронгуй болгох замаар мэдээллийн нэгдсэн сүлжээг баяжуулах;

3.4. Хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хүчирхийллийг бууруулах чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг тогтмолжуулах;

3.5. “Сургуулийн цагдаа” эцэг, эхийн эргүүлийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчиллах, идэвх оролцоог нэмэгдүүлэх;

3.6. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, цахим орчин дахь хүүхэд хамгааллын чиглэлээр зөвлөмж, гарын авлага тараах, сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах;

Зорилт 4 Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчлийг бууруулах чиглэлээр урьдчилан сэргийлэх сургалт явуулж, гудамж талбайд хяналт тавих зорилгоор төле хяналтын камерын тоо, цэгийг нэмэгдүүлж, тогтмол хяналт тавих;

Үр дүн 4.1. Жолооч нарын хариуцлага дээшилж, хүүхэд, иргэдийн мэдлэг сайжирч, зам тээврийн осол гэмтэл 50 хувиар буурсан байна.

Зорилт 4 -ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1. Замын хөдөлгөөний зохицуулагч нарыг жолоочийн согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн эсэхийг тогтоох болон хурд хэмжих багажаар хангах ажлыг зохион байгуулах;

4.2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн объектив, субъектив шалтгаан нөхцөлийг нарийвчлан тогтоох чиглэлээр салбарын мэргэжилтнийг бэлтгэх, мэргэшүүлэх, давтан сургах ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах;

4.3. Аймгийн хатуу хүчилттай авто замын тоог 2 дахин нэмэгдүүлж, замын тэмдэг, тэмдэглэгээ, гэрэлтүүлэг, хашлага, гарцыг оновчтой байрлуулах чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах;

4.4. Зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд иргэдэд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах эрх зүйн боловсрол олгох, ухамсар, соёлыг төлөвшүүлэх талаар иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих, хамтын ажиллагааг өргөжүүлэх;

Зорилт 5 Байгаль цаг агаарын болон хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй эрсдэл эмзэг байдлыг бууруулах, ард иргэдийн ажиллаж амьдрах аюулгүй орчныг бүрдүүлэх;

Үр дүн 5.1. Байгаль цаг агаар, хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй гамшиг, ослын тоо хохирол болон объект, ой, хээрийн түймрийн тоо буурсан байна.

Зорилт 5-ын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.1. Байгаль цаг агаарын аюулт үзэгдэл, ой, хээрийн болон объектын гол түймрийн аюул, үер ус, уул уурхайн ослоос урьдчилан сэргийлэх талаар ард иргэдэд сургалт зохион байгуулж аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх;

5.2. Ой, хээрийн түймэр гарах эрсдэл бүхий 8 сумд урьдчилан сэргийлэх, хяналт, сургалт сурталчилгааг зохион байгуулах, малчдын аюулгүй байдлыг хангах;

5.3. Хүн малын гоц халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах;

Зорилт 6 Хүүхэд, залуучуудыг гэмт хэрэг үйлдэх, гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг салбар дундын уялдаатай хэрэгжүүлж, гэр бүл, хүүхэд, залуучуудад ээлтэй амар тайван орчинг бүрдүүлэх;

Үр дүн 6.1. Гэр бүлийн хүчирхийлэл, цуцалт, хүүхэд, залуучууд оролцсон гэмт хэрэг, зөрчил 10 хувиар буурч, ээлтэй амар тайван орчныг бүрдүүлсэн байна.

Зорилт 6-ын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа


6.1. Архи, тамхины хууль болон хорт зуршлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр жил бүр аян зарлах;

6.2. “Хүүхэд хүүхдээ хамгаалья” клубын үйл ажиллагааг идэвхжүүлж, хүүхдийн эрсдлийн түвшинг тогтоох програм ажиллууллах;

6.3. 21-ээс доош насны хүмүүст архи, согтууруулах ундаагаар үйлчлэхгүй байх хуулийн хэрэгжилтэд төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран хагас бүтэн жилд хяналт шалгалт хийх;

6.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдэд чиглэсэн эрүүл мэндийн сургалт, зөвлөгөө, сэтгэл зүйг дэмжсэн арга хэмжээ зохион байгуулах;

6.5. Хүүхэддээ хараа хяналт багатай эцэг эхийн дунд Хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн тухай хуулиар сургалт зохион байгуулах;



6.6. Ахмад багш нарын оролцоотойгоор зорилтот бүлгийн өрхийн хүүхдүүдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор багийн төвүүдийг түшиглэн урлаг, спорт, гар урлал, амьдрах ухаан, эрүүл аж төрөх, өв уламжлалаас суралцах зэрэг төрөл бүлийн дугуйлан хичээллүүлэх;

6.7. Мэргэжлийн чиг баримжаа олгох төвтэй хамтран ажилгүй гэмт хэрэгт өртэж болзошгүй залуучуудыг нийгэмшүүлэх 6 сарын аяныг тусгай удирдамж хөтөлбөрөөр зохион байгуулж, бизнестэй холбох;

6.8. Залуучуудын талаар бодлого, хөтөлбөрүүдийг боловсруулах, дүн шинжилгээ хийхэд шаардлагатай мэдээллийн сантай болох;

6.9. Гэр бүл, хүүхэд, залуучуудад чиглэсэн сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах;

6.10. Эрчүүдийн манлайллыг сайжруулах, хүүхэддээ үлгэр дуурайлал болох төрөл бүрийн арга хэмжээ хэрэгжүүлэх;

6.11. Багийн иргэдийн нийгмийн оролцоог сайжруулах ажлын хүрээнд “SASA” аргачлалыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;

Зорилт 7 Иргэдэд хууль зүйн мэдлэг, эрх зүйн боловсролыг нээлттэй, хүртээмжтэй хэлбэрээр эзэмшүүлэх замаар өдөр тутмын амьдралдаа хэрэглэх чадварыг нэмэгдүүлэх;

Үр дүн 7.1. Эрх зүйн албан бус сургалт, сурталчилгааны ажлыг зөв оновчтой зохион байгуулсанаар тодорхой иргэдийн хууль, эрх зүйн анхан шатны мэдлэгийн төвшин дээшилж, иргэд эрх зүйн харилцаанд ухамсар соёлтойгоор оролцож, хууль тогтоомжийг амьдралдаа хэрэглэх, эрх ашгаа хамгаалах чадвартай болсон байна.

Зорилт 7-ын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

7.1. Иргэд, олон нийтийн хэрэгцээ сонирхолыг харгалzan хууль зүйн мэдлэг олгох, эрх зүйн боловсролыг дээшлүүлэх;

7.2. Иргэд, төрийн албан хаагчдын дунд хууль, эрх зүйн сэдэвт уралдаант тэмцээнийг жилд нэг удаа зохион явуулах;

7.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоотой хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх;

7.4. Хүний эрх, нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, гэр бүлийн маргаан зэрэг иргэдийн амьдралын хэрэгцээнд нийтлэг тулгардаг эрх зүйн маргаан, түүнийг хэрхэн шийдвэрлэх, зайлшгүй мэдэх шаардлагатай хууль тогтоомжийг хялбаршуулан тайлбарлан таниулах;

Зорилт 8 Байгаль орчны бохирдол, хог хаягдлаас урьдчилан сэргийлэх;

Үр дүн 8.1. Байгаль орчны бохирдол буурч, хөрсний бохирдлыг 40 хувиар бууруулсан байна.

Зорилт 8-ын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

8.1.Агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах дэд хөтөлбөрийг боловсруулан батлуулах

8.2. Иргэд, ЕБС-ийн сурагчдад байгаль орчныг хамгаалах сэтгэхүйг багаас нь төлөвшүүлэх, экологийн боловсрол олгох, байгаль орчны хууль тогтоомжийг сурталчилан таниулах, сургалт сурталчилгаа зохион байгуулж, байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг аймаг орон нутгийн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэх

8.3.Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийн хог хаягдлыг төрөлжүүлэн ангилан ялгадаг болох

8.4.Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, айл өрхөд ногоон байгууламж бий болгох сайн туршлагыг нийтэд сурталчлах

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга замууд

5.1.Аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцан орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэхэд удирдлага арга зүйгээр хангаж ажиллана.

5.2.Хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг аймгийн Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн баталгаажуулж бүх сумдад хүргүүлнэ.

5.3.Хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа бүрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт бүрийг төлөвлөн эзэнжүүлж, хэрэгжилтийг зохион байгуулах чиглэлээр аймгийн Засаг даргын захирамжаар үүрэгжүүлж, хяналт тавих ажлыг Хууль, эрх зүйн хэлтэс танилцуулна.

5.4.Төсөл арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн тайланг жил бүр аймгийн Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлж аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулж, үнэлүүлнэ.


Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, удирдлага зохион байгуулалт

6.1.Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь Монгол Улсын хууль тогтоомж, эрх зүйн акт болон бусад баримт бичгийн дагуу зохион байгуулагдана.

6.2.Дэд хөтөлбөрийг зохион байгуулах аймгийн зөвлөлийг аймгийн Засаг дарга ахлах бөгөөд орлогч дарга нь Засаг даргын орлогч, бүрэлдэхүүнд нь аймгийн ЗДТГ-ын хэлтэс, агентлагийн дарга нар, сумдын Засаг дарга нар, орон нутгийн хэвлэл мэдээлийн ажилтнууд орно.

6.3.Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд аймгийн бүх сумдад салбар зөвлөл ажиллах бөгөөд түүнийг сумдын Засаг дарга нар ахалж, орон нутгийн төрийн захиргааны болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөл орсон байна.

6.4.Дэд хөтөлбөрийн холбогдох заалтуудыг аймгийн Засаг даргын хэлтэс агентлагийн дарга нар болон сумдын Засаг дарга настай байгуулах үр дүнгийн гэрээнд тусгуулж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.



Долоо. Хэрэгжилтийн үнэлгээний арга хэлбэр, үе шат

7.1.“Амар тайван амьдрал” хөтөлбөрт тусгагдсан зорилтын хүрээнд жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ.

Нэгдүгээр үе шат буюу 2017-2018 он /2018 оны 03 дугаар сард үнэлгээ хийх/

Хоёрдугаар үе шат буюу 2018-2019 он /2019 оны 03 дугаар сард үнэлгээ хийх/

Гуравдугаар үе шат буюу 2019-2020 он /2020 оны 03 дугаар сард үнэлгээ хийх/

7.2. Явцын үнэлгээ буюу мониторингийг нэг жил тутамд зохион байгуулж, эцсийн үнэлгээг 2020 онд зохион байгуулж, дүнг мэдээлж ажиллана.

7.3. Төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг аймгийн ажлын хэсэг аймгийн Засаг дарга, Хууль, эрх зүйн хэлтсийн даргад мэдээлж, тайлagnaх ба хэлтсийн тухай асуудлыг хариуцсан мэргэжилтэн, Цагдаагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Онцгой байдал газар иргэдэд мэдээлэх ажлыг хариуцан зохион байгуулна.

7.4. Биелэлтийн явц, үр дүн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг Хууль, эрх зүйн хэлтсийн дарга холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлүүлнэ.

Найм.Хөтөлбөрийн санхүүжилт

8.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ.

8.1.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгө

8.1.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө

8.1.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зориулалтаар улсын төсвөөс орон нутагт тусгагдсан хөрөнгө,тоног төхөөрөмжийн дэмжлэг

8.1.4. Бусад эх үүсвэр

8.2. Хөтөлбөр хэрэгжүүлэхэд төрөөс үзүүлэх дэмжлэгийг иргэн, аж ахуйн нэгжийн өөрийнх нь хөрөнгө оруулалттай хослуулан хөтөлбөрт заасан үр дүнд хүрэх хариуцлагын тогтолцоог бүрдүүлнэ.

Ес. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

9.1. Дэд хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ.

9.1.1. Дэд хөтөлбөрт тусгагдсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөө

9.1.2. Мал хулгайлах, орон байрны хулгайн гэмт хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлт

9.1.3. Гэр бүлийн хүчирхийлэл, насанд хүрээгүй хүүхдийн үйлдсэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөө

9.1.4. Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчлийн гаралт

9.1.5. Олон нийт-Цагдаагийн хамтын ажиллагаа сайжирсан байдал

9.1.6. Гамшгаас хамгаалах менежментийн сургалт, сурталчилгааг бүх түвшинд зохион байгуулснаар иргэд, аж ахуй нэгж, байгууллагын удирдлага, ажилтнуудын гамшгаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, эрсдлийг бууруулах талаар мэдлэг дээшилсэн байна.

9.1.8.Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаандаа дагаж мөрдвөл зохих стандартын хэрэгжилт хангагдаж, хяналт шалгалтын үр дүн дээшилсэн байна.

9.1.9.ХБХ-тэй 50 эцэг, эхэд чиглэсэн тэмцээн уралдаан, сургалт зохион байгуулсан байна.

9.1.10.Баянхонгор сумын 15-34 насны залуучуудын эрсдэлт хүчин зүйлүүдийн судалгааг мэргэжлийн байгууллагатай хамтран гаргасан байна.

9.1.11.Сургуулийн орчинд багш нарын заах арга, сурагчдын идэвх оролцоо, харилцаа, сурлагын төвшин, эцэг, эхчүүд хүүхэдтэй харилцах харилцаа, хүүхдүүдэд тавих анхаарал халамж сайжирсан байна. Аймгийн хэмжээнд эрсдэлтэй байж болзошгүй хүүхдүүд хамгаалагдсан байна.

9.1.12.Гэр бүлийн сургагч багш нараар дамжуулан 5 модуль сургалтыг зохион байгуулж нийт өрхийн 10 хувьд хүрсэн байна.

9.1.13.Аймгийн хэмжээний нийт өрхийн судалгааг 26 үзүүлэлтээр гаргах.

9.1.14.Иргэдийн хууль, эрх зүйн мэдлэг дээшилсэн байх

9.1.15.Аймгийн хэмжээний хог хаягдал, агаарын бохирдол буурсан байх зэргийг харгалзана.